

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Барилга угсралтын даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Барилга угсралтын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүн шинэчлэх тухай		2021-02-05		ЗТ-21-02-011	
6	Цахимаар борлуулах эсэх	Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Барьж буй бүх төрлийн барилга, байгууламж, талбай дахь бүх төрлийн бараа, техник, тоног төхөөрөмж, машин, механизм					
	Даатгалын үндсэн эрсдэл	Байгаль, гал, сантехник, цахилгаан, гуравдагч этгээд					
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.11%-0.8%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Даатгуулагч, түүний ажилтны гэмт хэрэг, зөрчлийн шинж чанар, зорилготойгоор үйлдсэн санаатай үйлдлийн улмаас учруулсан аливаа хохиролд;
2. Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын зүйлд гарсан хохирлоос үүдэн гарсан эдийн засгийн алдагдалд;
3. Даатгалын тохиолдлын улмаас газар, шороо, хөрс, агаар, газрын хэвлийн болон байгаль орчинд учирсан хохиролд;
4. Даатгуулагч, түүний ажилтны согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үед хийсэн үйлдлийн улмаас үүдсэн хохиролд;
5. Хууль, дүрэм, журам, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологи, батлагдсан барилгын зураг төслийг илтгэд эсхүл санаатай зөрчин үйл ажиллагаа явуулсны улмаас учирсан хохиролд;
6. Эрх бүхий байгууллагаас олгогдох тусгай зөвшөөрөлгүйгээр болон зөвшөөрлийн хугацаа дууссан байхад үйл ажиллагаа явуулснаас үүдэн гарсан хохиролд;
7. Даатгуулагчийн барилгын ажлыг гүйцэтгэх зорилгоор бусад аливаа этгээдтэй байгуулсан гэрээний дагуу төлөгдөх анз, дэнчин, баталгаа, эрх бүхий байгууллагаас ногдуулсан торгууль, төлбөр;
8. Тусгай мэдлэг, мэргэшил шаардсан ажил албан тушаалд мэргэжлийн бус ажилтныг ажиллуулснаас үүдсэн хохиролд;
9. Зөвшөөрөл бүхий барилгын ажлын талбай, цэгээс бусад газарт явуулсан барилгын ажлаас үүдэн гарсан хохиролд;
10. Эрх бүхий байгууллагаас зөвшөөрөгдөөгүй эсвэл хэрэглэхийг хориглосон аливаа барилгын материалыг хэрэглэсний улмаас учирсан хохиролд;
11. Гүний, хөрсний усны улмаас учирсан болон хүний нөлөөтэйгээр үүссэн хөрсний нуралт, гулгаанаас үүдсэн хохирол;
12. Эдэлгээний хугацаа дууссан, ашиглахыг хориглосон, бүрэн бус, эвдрэлтэй техник, тоног төхөөрөмжийг барилгын ажилд хэрэглэсний улмаас учирсан хохирол;
13. Даатгуулагчийн В, С, D ангиллын тээврийн хэрэгсэлд учирсан хохирол;
14. Даатгуулагчийн барилгын зураг төсөл, план, бусад бичиг баримт утсан, гэмтсэн, алга болсноос үүдсэн зардал;
15. Даатгалтай хөрөнгө төхөөрөмжийн техникийн үйлчилгээ хийхтэй холбогдон гарах зардал, техникийн үйлчилгээгээр сольсон эд ангиудын зардал;
16. Түр далан задарснаас үүдэн гарсан хохирол;
17. Эд хөрөнгийн ердийн элэгдэл, бараа материалын хэвийн хорогдол, ууршилт зэрэг тухайн эд хөрөнгө бараа материалын шинж чанараас шалтгаалан гарсан хохиролд нөхөн төлбөр олгохгүй;
18. Техник тоног, төхөөрөмжийн ашиглалтын горим, журмыг зөрчсөн, даац, ачаалал хэтрүүлсэн, шалган турших зорилгоор хэвийн бус байдлыг бий болгосноос үүссэн хохирол;
19. Гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалын хувьд гуравдагч этгээд нь даатгалын тохиолдлыг өөрөө бий болгосон болох тогтоогдсон тохиолдолд;
20. Гэрээнд өөрөөр заагаагүй бол барилгын материал, техник тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн үед гарсан хохирол;
21. Ашиглалтын хугацаа дууссан эд ангиуд болон туслах, дагалдах материалуудыг ашигласны улмаас учирсан аливаа хохирол;
22. Үйлдвэрлэлийн дефектээс болон буруу суурилуулсан, угсарсан, задалсанаас үүдэн гарсан болон тэдгээрийг засварласан аливаа зардал.
23. Хууль тогтоомжид заасан бусад.